

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ 2 ДУГААР УЛИРАЛД БҮРТГЭЛ ХЯНАЛТАД АВСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2023 оны 07 дугаар сарын 25

Мандалговь хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар улиралд батлан гаргасан захирамжийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Аймгийн Засаг даргын батлан гаргасан захирамжийн 2023 оны 2 дугаар улирлын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалаар хийлээ.



Аймгийн Засаг даргын батлан гаргасан захирамжаас 2023 оны 2 дугаар улиралд 44 захирамжийн 48 заалтыг хяналтад авч, Төрийн захиргааны, удирдлагын хэлтэс холбогдох сум, хэлтэс, агентлагуудаас биелэлтийг гаргуулан авч нэгтгэн тайланг 2023 оны 7 сарын 20-ны өдөр эцсийн байдлаар ирүүлсэн.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2023 оны 2 дугаар улиралд хяналтад авсан 44 захирамжийн 48 заалт 91.3 хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс 100 хувь -35, 90 хувь-2, 70 хувь -5, 30 хувь -3, хугацаа болоогүй 3 заалт байна.

Эхний хагас жилийн хэрэгжилттэй харьцуулахад 3.5 хувиар ахисан байна.

Хэрэгжилтийн хувь болон эзлэх хувийг графикаар харуулбал:



Дүнгээс харахад: Бүрэн хэрэгжсэн буюу 100 хувьтай 35 заалт нь нийт заалтын 72.9 хувийг, хэрэгжих шатандаа буюу 90 хувьтай хэрэгжиж байгаа 2 заалт нь 4.1

хувийг, 70 хувьтай хэрэгжиж байгаа 5 заалт нь 10.4 хувийг, хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай хэрэгжиж байгаа 3 заалт нь 6.2 хувийг тус тус эзэлсэн байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Аймгийн Засаг даргаас батлан гаргасан захирамжийг 2023 оны 2 дугаар улиралд 91.3 хувьтай хэрэгжиж байна. Энэ улиралд хэрэгжилт тооцсон захирамжуудаас дараах заалтууд хэрэгжилт удаашралтай байгаа болон эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр дүгнэж, зөвлөлд танилцуулж байх

Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэн хэрэгжилтийн талаар удирдлагууд болон иргэдийг мэдээллээр хангаж ажиллах

Төсөл санхүүжүүлэх тухай захирамжийн хавсралтын дагуу төслүүдийг санхүүжүүлэх ажлыг эрчимжүүлж төслийн хэрэгжилт үр дүнд хяналт тавьж хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод нээлттэй болгох

Өгсөн зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 3 улирлын захирамжийн хэрэгжилттэй хамт ирүүлэх

Тайлан хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн дарга

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт- шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг